

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 02 сарын 19-ны өдөр

Дугаар

БА-057/2025

Улаанбаатар хот


Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд баригдсан өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар 1 блок 30.0м*20.0м хүчин чадал бүхий гоо заслын эмнэлэг, оффис, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 13 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 дүгээр сарын 03-ний өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2022-11-04 огноо, 0012070 дугаар, 886/2022, Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2024-05-10 огноо, 0000099 дугаар, БА32024/0046;
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЕГ Шифр: ЭД-А3-06-2022;
- 2.3. Захиалагч: Монгол Улсын иргэн Арвижих овогтой Цэгмид эцэг эхийн нэр, Гантөмөр нэр, ЗЮ 74082971 регистрийн дугаар;
Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 18 дугаар хороо, Дөрвөн улирлын цэцэрлэг 4 байр 902 тоот, 99111556 холбоо барих утас;
- 2.4. Барилгын ажлын гүйцэтгэгч: "Энхбагана Констракшн" ХХК оноосон нэр, 9011453065 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5783755 регистрийн дугаар, БУ11-711/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 3 дугаар хороо, Замчдын гудамж, 214А байр 401 тоот, Холбоо барих утас: 88101011, enkhbaganallc@gmail.com цахим хаяг;
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: "Хар шонхор илч" ХХК оноосон нэр, 9011450014 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5776589 регистрийн дугаар, БУ12-167/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8 дугаар хороо, Эрдэнэ толгой 40 дан 1 тоот, 95745011 холбоо барих утас;

"Инфинити вишион" ХХК оноосон нэр, 9011861954 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 3804577 регистрийн дугаар,



Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 10 дугаар хороо, морин 7-301 тоот, 85133535 холбоо барих утас;

“Тоть рус союз” ХХК оноосон нэр, 9011669138 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5121256 регистрийн дугаар, ӨБ16-164/23 тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 4 дүгээр хороо, Сөүлийн 2045, 205 тоот, 77111848 холбоо барих утас,

“Файна виндов” ХХК оноосон нэр, 9011600069 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6068723 регистрийн дугаар, №521/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 9 дүгээр хороо, 3-р хороолол уулзвар төв 307 тоот, 99117376 холбоо барих утас;

“Макс Фасад” ХХК оноосон нэр, 9011822970 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6639178 регистрийн дугаар, БУ11-875/23 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар,

Хаяг: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 28 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө 302-70 тоот, 80438080 холбоо барих утас;

2.6. Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: “Эдшил” ХХК оноосон нэр, 9011124086 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2071991 регистрийн дугаар, ЗТ19-309/24 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 6 дугаар хороо, их сургуулийн 35, 701 тоот, 11-311383, 99113422 холбоо барих утас;

2.7. Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газар ОНӨААТҮГ оноосон нэр, 9014001026 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2117118 регистрийн дугаар, БУ19-48/23 тусгай зөвшөөрлийн дугаар,
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Их тойруу, өөрийн байр, 70005454 холбоо барих утас, www.osnaucg.ub.gov.mn цахим шуудангийн хаяг;

2.8. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

- ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:
 - Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул
- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангасан тул

ШАЛГАЛТЫН
ХЭСЭЛ
Байгууламжийг ашиг
лалтын комисс

3.1 Энэ өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар 1 блок, 30.0м*20.0м хүчин чадал бүхий гоо заслын эмнэлэг, оффис, үйлчилгээний зориулалттай барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.3 Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт .. хуудас, хуралдааны тэмдэглэл ... хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хавтас хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Өндөр төвөгшилтэй ангиллын зорьтой 9 давхар 1 блок, 30.0м*20.0м хүчин чадал бүхий гоо заслын эмнэлэг, оффис, үйлчилгээний зориулалттай барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, иргэн Ц.Гантөмөрийн захиалгатай
эмнэлэг, оффис, үйлчилгээний барилга

Комиссын дарга: Нийслэлийн Хяналт шалгалтын
газрын Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



алтанд

(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Захиалагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч:
Төгс Ялгуун Медикал ХХК-н гүйцэтгэх захирал



(Г.Намуун)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын
биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



СҮХБААТАР ДҮҮРГИЙН 9 ДҮГЭЭР ХОРОО, ИРГЭН Ц.ГАНТӨМӨРИЙН
ЗАХИАЛГАТАЙ ЗООРЬТОЙ 9 ДАВХАР “ТӨГС ЯЛГУУН-2” ЭМНЭЛЭГИЙН
БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД ОРУУЛАХ
КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 01 дүгээр сарын 03

Улаанбаатар хот

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороонд иргэн Ц.Гантөмөрийн захиалгаар баригдсан зоорьтой 9 давхар 1 блок, “Төгс ялгуун-2” гоо заслын эмнэлэг, оффис, үйлчилгээний барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын 1 дүгээр давхрын үйлчилгээний танхимд 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр 14:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 16:00 цагт дуусав.

ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

Ц.Гантөмөрийн захиалгаар
Барилга байгууламжийг ашиглалтад
орлуулах комисс

Хуралд:

1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батчимэг
2. Нарийн бичгийн дарга: иргэн Ц.Гантөмөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Намуун
3. Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч Н.Ёндонсамбуу
4. Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч З.Очирпүрэв
5. Улаанбаатар Дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын хэлтсийн дарга Б.Оргил
6. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын инженер Б.Цэрэннадмид
7. Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн Н.Даваадэмид
8. Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчид үйлчлэх төвийн менежер Ө.Шинэцэцэг
9. Онцгой байдлын ерөнхий газрын Зураг төсөл хяналтын байцаагч, дэд хурандаа М.Батсайхан
10. Үндэсний Төв Архивын Зураг төслийн баримтын архивын архивч Б.Оюунжаргал
11. Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга Д.Батням
12. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага, Монголын тэргэнцэртэй иргэдийн холбооны хүтээмжийн үнэлгээний ажилтан Б.Ганбаатар
13. Ашиглагч хариуцах Орон сууц, нийтийн аж ахуйн

удирдах газрын Зүүн түгээх төвийн Засварын ахлагч
14. Зохиогч Эдшил ХХК-ийн захирал
15. Гүйцэтгэгч Энхбагана констракшн ХХК-ийн
Төсөл хариуцсан захирал

Ю.Галхүү
Ө.Ганболд

Б.Хашболд

ИРЦИЙН БАЙДАЛ:

- Мэдэгдэл хүлээн авсан - 15
- Хүрэлцэн ирсэн - 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан – 15

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, зорьтой 9 давхар, 1 блок “Төгс ялгуун-2” эмнэлэгийн барилгын барилгын ажлын баримт бичгийн бүрдэл, барилгын ажлын гүйцэтгэл нь ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөв, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч **Н.Ёндонсамбуу**:

1. Дээврийн ус зайлуулах хоолойнд хог шүүгч хийх.
2. Лифт албан шаардлага биелэлт үзүүлэх.
3. Барилгын тухай хуулийн дагуу баталгаа албан тоот ирүүлэх.
4. Хүүхдийн тоглоомын талбайруу ус зайлуулах хоолой гаргасан асуудлыг шийдэх. /зураг үзүүлэх/
5. Бетоны лабарторын шинжилгээг үзүүлэх.
6. Ашиглалттай дээвэр тайлбар албан тоот өгөх.
7. Гадна фасад, дотор засал хийсэн компани аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрөл үзүүлэх.
8. Барилгын ажилд тусгагдсан хаалгыг сольж хийх. /ХО1/
Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсын ахлах байцаагч **З.Очирпүрэв**:

1. 152-р ус дулаан дамжуулах төвийн өргөтгөл шинэчлэлийн ажлыг бүрэн дуусгаж, ОСНААУГ-т хүлээлгэн өгөх.
2. Холигч насосны узелийн цэврэлгээ хаягжуулалт хийх, ус зайлуулах трап томсгож усыг зайлуулах шийдэл гаргах.
3. Давхруудын АС-ийн механик систем агаар сорох, агаар өгөх системийн шугамуудыг өрөөнүүдэд зургийн дагуу бүрэн угсрах.
4. АС-ийн моторын дуу чимээг ажиллах нөхцөлд тохиромжтой стандартад нийцэж байгаа эсэхийг хэмжилт хийж баталгаажуулах.
/Дуу чимээг багасгах/
5. Дээвэр дээрх ердийн системийн шахтыг прапетнаас дээш 50см-с доошгүй өндөрлөх.

ХЯНА
Барилга бай
о

6. Үнэр гаргагчийг малгайвчнаас дээш гаргаж дулаалах.
 7. Халуун бөгчим өрөөнүүдэд агаарын хэвлийн хэмжээнд байх эсэхэд хэмжилт хийлгэн авторын нэгдсэн дүгнэлтэд тусгуулах мөн хөргөлтийн систем шаардлаггүй талаар баталгаа гаргах.
 8. Халаах хэрэгсэлд термостат угсрах.
 9. Гражын хаалганд халуун хөшиг угсрах.
 10. Гадна, дотор Салхивч, ус, дулааны ил далд ажлын акт шалгуулах.
 11. Дотор хэрэглэсэн сангийн шугамын тохирлын гэрчилгээ.
- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулахад татгалзах зүйлгүй.

Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК-ийн Шинэ хэрэглэгчийн холболтын албаны дарга **Д.Сүхбат**:

1. Халаах хэрэгсэлд тринометр винтель тавих.
2. Дулааны узель цэвэрлэх хаягжуулалт хийх. Дулаан сэргээх. Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн Техник хяналтын инженер **Ц.Наранцацрал**:

1. 0.4кв щитний газардуулга болон аяндын буултын эсэргүүцлийг хэмжүүлж протокол авах.
2. 0.4кв кабелийн ил далд ажлын актыг нөхөж үзүүлэх.
3. Хүчит төхөөрөмж /гэрэлтүүлэг, аянга, разетка, газардуулга/-ийн ил далд ажлын акт, фото актыг нөхөн бүрдүүлж гарын үсгээр баталгаажуулах.
4. Хүчит төхөөрөмжийн угсралтыг гүйцэтгэлийн зургаар баталгаажуулах.
5. Давхар дундын щитэнд схем, хаягжуулалт хийх.
6. Аянга хүлээн авагч байрлуулах.
7. Ерөнхий щитийг хөдөлгөөнгүй бэхлэх, хаяг схем байрлуулах, Б/давхарлуу татсан кабелийг битүү тавиураар татах.
8. Барилга баригдах үеийн төлбөр тооцоог барагдуулсан баримт нөхөж үзүүлэх, лацгүй тоолуур, хэмжих хэрэгслээр цахилгаан хэрэглээнд нөхөн бичигт хийнэ.
Дээрх үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтанд хүлээн авах саналтай байна.

Ус сувгийн удирдах газрын Хэрэглэгчдэд үйлчилэх албаны шинэ хэрэглэгчдэд үйлчлэх албаны менежер **Б.Жамбалжанцанжид**:

1. Гадна ДХ-1-т шугам сүлжээг дулаалах, цэвэр усны огтолгооны хаалтыг фланцет хаалтаар солих.
2. Бохир усны худаг-2-ыг стандартын дагуу болгох, гаргалгаа худгийг шалгуулах.
3. Борооны ус зайлуулах шугамын усыг бохир усны худагруу оруулахгүй байх арга хэмжээг авах.
4. ОСНААУГ-аар далд ажлын актыг баталгаажуулах.
5. Узелийг цэвэрлэх ус зайлуулах трап хийх.
6. ГЦХ-т галын гидрант суурилуулах.
7. Нөөцийн савны халдваргүйжүүлэлт хийлгэх, усны шинжилгээ хийлгэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр хүлээж авах.

Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газар, Барилгын зураг төсөл хяналтын байцаагч, Дэд хурандаа **М.Батсайхан**:

1. ГК гал унтраах дотор усны даралтат цэгийг хэвийн болгох.
2. Гал унтраах автомат спранклерийн системийг туршиж шалгаад видео бичлэгээр ирүүлэх.
3. Шатны хонгилыг тусгаарлах галд тэсвэртэй хаалганд өөрөө хаагч тоноглол хийх.
4. Шатны хонгилд даралттай агаар өгөх системийг хэвийн болгох.
5. Нийтийн эзэмшлээс утаа сорох систем 2, 3, 4, 5-р давхарт шилэн хаалтаар тусгаарлагдаж байгаа норм дүрмийн дагуу болгох.
6. Барилгын гадна хананы гал тэсвэршилтийн зэрэг тогтоолгосон дүгнэлт үзүүлэх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Үндэсний төв архивын Зураг төслийн баримтын архивын архивч **Б.Оюунжаргал**:

1. Архивд баримтаа баримт бүрдүүлэх нийтлэг жагсаалт “Барилга байгууламж ашиглалтад оруулах дүрэм”-ийн 5-р хавсралтын дагуу бүрэн бүрдүүлж өгөх.
2. БҮ-ийн тэмдэглэл дэвтэр бүрэн баталгаажуулж, гарчиглаж өгөх.
3. Ажлын болон өөрчлөлт зургийг, зургийн бүрдлийн дагуу бүрэн бүрдүүлэн эх хувиар өгөх.
4. БҮ-ийн болон бусад ажлын ил, далд ажлын акт, гэрэл зургийг ажлын дараалалаар ботьлон эх хувиар дотоод товъёог үйлдэж өгөх /гарын үсгийн бүрдэл хангах/
5. Хувийн хэргийг нийтлэг жагсаалтын дагуу бүрэн бүрдэлтэй дотоод товъёог хийж өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Барилгын хөгжлийн төвийн Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн дарга **Д.Батням**:

1. Зоорийн давхрын байгуулалт өөрчлөгдсөн үзель зөөгдсөн.
2. Усны узель ус цуглуулагч хангалтгүй.
3. Барилгын материалын тохирлын гэрчилгээ дутуу
4. Усны нөөцийн сав ариутгал хийх.
5. Барилгын ажил гүйцэтгэх зөвшөөрөл дууссан.
6. Нормчлолын сангийн төвлөрүүлэлт хийх. Тооцон төлөлт хийх.

Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллага төлөөлөл **Б.Ганзориг**

1. Гадна авто зогсоол дээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан зогсоол төлөвлөлт хийж, тэмдэг тэмдэглэгээ хийх.
2. Орц хэсэгт төлөвлөсөн налуу зам стандартанд нийцэхгүй байгаа тул стандартын дагуу болгож өөрчилөх. /MNS-68082019/

3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөг шаардлагатай тоноглолоор тоноглох /MNS-60562009/
 4. Дутуу байгаа ханын бариулыг гүйцээж хийх.
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газрын Зүүн түгээх төвийн Засварын ахлагч **Ю.Галхүү:**

1. Узель-д хаягжуулалт, тоос шороог арчиж, цэвэрлэх.
2. Ф900 шугамын буцах дээрээ балансын хаалт тавих.
3. Ил далд ажлын акт ОСНААУГ-н зүүн түгээх төвөөр зуруулах.
4. Техникийн тодруулгын дагуу автомат хаалт авч өгөх.

Үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээн авахад татгалзах зүйлгүй.

Мэдээлэл Холбоо Сүлжээ ТӨХК-ийн Технологийн удирдлага төлөвлөлтийн газар Чанар хяналтын хэлтсийн мэргэжилтэн **Н.Даваадэмид:**

1. Акт бичиг баримтыг нөхөн үзүүлэх.
2. Гадна холбооны ерөнхий оролтоос холбооны техникийн өрөө хүртэл кабель шугамын тавиур хийж гүйцэтгэх.
3. Холбооны өрөө болон кабель шугамын тавиурыг хаягжуулах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Зохиогч “Эдшил” ХХК-ийн захирал **Ө.Ганболд:**

1. Хойд талын гадна ослын шатыг сэргээж будах.
2. Гадна тохижилтыг дутуу ажлуудыг гүйцэтгэх. Үүнд: пандусны бетонд хийсэн зүсэлтийг /кабель явуулах/ цэвэр үзэмжтэй битүүмж хийх.
3. Борооны ус буух цоргыг засах.

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

Захиалагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Төгс Ялгуун Медикал ХХК-ийн гүйцэтгэх захирал **Г.Намуун:**

- Улсын комиссын үүрэг даалгаврын биелэлтийн дагуу байнгын ашиглалтанд оруулах саналтай байна.

Гүйцэтгэгч Энхбагана констракшн ХХК-ийн Төсөл хариуцсан захирал **Б.Хашболд:**

- Улсын комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтийн дагуу байнгын ашиглалтад авах саналтай.

Нийслэлийн Хяналт шалгалтын газрын Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч **Б.Батчимэг:**

1. БТХ-ийн 14.3 14.6 заалтын дагуу чанарын баталгааг албан бичгээр гаргаж ирүүлэх.
2. Батлагдсан эх загвар зургийн дагуу дээвэр дээр төлөвлөсөн ногоон байгууламжийг хийх баталгаа ирүүлэх.
3. Зоорийн давхарт төлөвлөсөн аюултай хог хаягдал түр хадгалах өрөөнд тавигдах шаардлага хангуулсан тайлбар ирүүлэх. /Зохиогчоос ирүүлэх/

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, иргэн Ц.Гантөмөрийн захиалгатай зорьтой 9 давхар 1 блок, "Төгс ялгуун-2" гоо заслын эмнэлэг, оффис, үйлчилгээний барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлтийг баталгаажуулж, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:

Хяналт шалгалтын газрын
Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч



(Б.Батчимэг)

Тэмдэглэл хөтөлсөн:

Захиалагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч
"Төгс ялгуун медикал" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал



(Г.Намуун)